



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим
арга хэмжээний тухай

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 2017 оны А/107 дугаар тогтоолоор батлагдсан Хурлын дэргэдэх Нийгмийн бодлогын ажлын хорооны 2 ажлын хэсэг Сонгинохайрхан дүүргийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах ажлын удирдамжийн дагуу хуваагдан 25 сургууль, 42 цэцэрлэг нийт 67 байгууллагын үйл ажиллагаатай танилцан нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагын бодлого, шийдвэрийг сурталчлан улмаар тэдний санаа бодлыг судалж, цаашид холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх асуудал бүрийг тодорхойлсныг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх зүйлийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Засаг даргад даалгах нь:

1.1. "Ирээдүй цогцолбор" сургуулийн бүтцийг судалж, эрх мэдэл зөвхөн ерөнхий захиралд төвлөрч буй байдал нь тэдгээр сургуулиудад ажиллаж буй ажиллагсад болон сурч буй хүүхдүүдийн эцэг эхэд сургуулиас үзүүлэх үйлчилгээ холдон удаашрах зэрэг сөрөг үр дагавар гарч буй байдалд дүгнэлт хийж цогцолборт харъяалагддаг сургууль бүрийг гүйцэтгэх захиралтай байлгаж, дүүргийн Засаг даргатай шууд үр дүнгийн гэрээ байгуулж, ажил үүргийн хуваарийг шинэчлэн удирдлагын эрх мэдлийг тэгш хүртээмжтэй байлгахад анхаарах гэсэн тэнд ажиллагсдын тавьсан саналыг холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах

1.2. Сургууль, цэцэрлэгүүд эцэг, эхийн оролцоотой хандив тусламж, хууль бус төлбөр хураамж авч буй байдал их байгааг таслан зогсоох тухай иргэдээс ирүүлсэн гомдлын мөрөөр ажил зохион байгуулж, түүврийн аргаар сонгож,

дүүргийн Дотоод аудит болон Мэргэжлийн хяналтын хэлтсийн хамтарсан шалтгалтыг хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгуулах

1.3. Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хэрэглээний бохир усыг хувийн байгууллагаар соруулахад дунджаар 24000 төгрөгөөр гэрээ хийгддэг байсан бол дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ 35000-40000 төгрөгөөр соруулах гэрээг хийж байгаа зөрүүтэй үнийг тодруулан шийдвэрлэж өгөх тухай захирал, эрхлэгч нарын тавьсан хүсэлтийг судалж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бохир ус соруулах үнэ тарифыг тавьж шийдвэрлүүлэх

1.4.74 дүгээр сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, халуун ус, номын сан, 21 дүгээр хорооны захын хэсгүүдээс хүүхэд зөөж тээвэрлэх автобус, 176 дугаар цэцэрлэгийн гүний худгийн ус шинжилгээгээр муу гарсан, 42, 74, 105, 107 дугаар сургууль, 41, 90, 112, 113, 176, 195 дугаар цэцэрлэгүүдийн дээвэр, сантехникийн асуудал болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсээс сургалтын орчныг сайжруулах, хоол үйлдвэрлэлийн өрөө, хүнсний барааны агуулах, агааржуулалтын системд тавигдах шаардлага нэг бүрийг арилгуулах талаар гаргасан дүгнэлт нэг бүрийг сургууль, цэцэрлэгүүдээр гарган үе шаттай шийдвэрлүүлэх хүсэлтийг холбогдох дээд байгууллагад уламжлах, үр дүнг тооцох

1.5. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Хөтөлбөр батлах тухай" А/57 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт ёсоор батлагдсан "Сонгинохайрхан дүүргийн орон нутгийн болон төсвийн байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам"-ын дагуу боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэхэд анхаарах

1.6. Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдлагуудыг сонгон шалгаруулалтад яаралтай хамруулах хүсэлтийг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

2. Дүүргийн Боловсролын хэлтсийн даргын "Салбарын хууль тогтоомжоос гадна бусад хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хэрхэн хангуулах талаар зохион байгуулсан ажлын мэдээлэл"-ийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэх мөн "Хүнс хангамж" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай танилцах, сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, зах зээлийн үнэ ханшийг харьцуулан судалж, дүгнэлт хийх Ажлын хэсгийг тогтоолоор байгуулж ажиллуулахыг хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н. Мөнхбаатар/-д үүрэг болгосугай.

3. Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт даалгах нь:

3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын мөрдөлт дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хэмжээнд "Хангалтгүй" гэж дүгнэгдсэнтэй холбогдуулан байгууллага тус бүр архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан хууль тогтоомж, дүрэм журмыг нийт албан хаагчиддаа судлуулах, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах / тэднээс шалгалтыг тестээр авах/, холбогдох хууль журмыг үйл ажиллагаандаа хэвшүүлж буй байдалд хяналт тавих, архив бичиг хэргийн ажилтнаа сертификаттай сургалтад хамруулах зэрэг арга хэмжээг авч ажиллах

3.2. "Хүүхэд хамгааллын тухай" хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй гэсэн ажлын хэсгийн дүгнэлтэд анхаарч цаашид хүүхэд хамгааллын чиглэлээр зохион байгуулах ажлаа төлөвлөж, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлэн хорооны хамтарсан багт мэдээлж ажлаа уялдуулах, үе тэнгийнхний дарамт, хорт зуршилд өртөж буй байдалд хяналтыг тогтмол тавьж илрүүлэх, багш сурагчдын нөхөрсөг бус харилцаа, маргааныг эвлэрүүлэх, багш ажилчдын хүүхэд хүмүүжүүлэх эерэг ажлын арга, тэргүүн туршлагыг сурталчлан, гэмт хэрэг зөрчил гаргахгүй байх нөхцөл бүрдүүлж, хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн үйл ажиллагаатай ажлаа уялдуулах

4. Засаг даргын Тамгын газраар энэхүү тогтоолын биелэлтийн явцыг улирал тутам гаргуулан Нийгмийн бодлогын ажлын хорооны хурлаар хэлэлцүүлж, хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллахыг Нийгмийн бодлогын ажлын хороо /Э.Ууганцэцэг/-д даалгасугай.

ДАРГА



ЭНХЦЭЦЭГ